

## АЖИЛТАН СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЗАР

2026.01.29

**Албан тушаал:** Эрсдэлийн шинжээч

**Гүйцэтгэх үүрэг:**

Үндэсний Давхар Даатгал ХК-ийн даатгалын, зах зээл, хөрвөх чадварын эрсдэлийг тодорхойлох, тооцоолж хэмжих, хяналт тавих ба тайлагнах үйл ажиллагааг хариуцан ажиллана. Түүнчлэн удирдлагын шийдвэр гаргах үйл явцад шаардлагатай мэдээ, судалгаа шинжилгээгээр хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх санал зөвлөмж өгнө. Компанийн бизнес зорилго, эрсдэлийн соёл, эрсдэлийн хүлээн зөвшөөрөх мэдэгдлийн хүрээнд даатгалын, зах зээл, хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын үр ашигтай, тасралтгүй үйл ажиллагааг хангуулахын зэрэгцээ холбогдох баримт бичиг, үнэлгээний арга аргачлалыг тогтмол хөгжүүлэн, олон улсын шилдэг туршлага болон стандартад нийцүүлэн хэрэгжүүлэхэд энэхүү ажлын байрны зорилго оршино.

**Ажлын байранд тавигдах шаардлага:**

- Математик, статистик, эдийн засаг, санхүүгийн чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй;
- Компьютерын хэрэглээний программуудыг ахисан түвшинд эзэмшсэн;
- Мэргэжлийн чиглэлийн англи хэлний бичгийн болон ярианы ахисан түвшний чадвартай;

**Нэмэлт шаардлага:**

- Баримт бичиг боловсруулах, тайлан, мэдээлэл бэлтгэх чадвартай;
- Их өгөгдөл дээр ажиллах, шинжилгээ хийх, холбогдох программ хангамжийг ашиглах ур чадвартай;
- Тоон мэдээлэл ба санхүүгийн тайлан, түүний бүтцийг задлан шинжлэх дүгнэлт хийх ур чадвартай;
- Эдийн засаг ба банк санхүүгийн салбарын өргөн мэдлэгтэй;
- Эрсдэлийг бууруулах арга хэрэгслийг ойлгодог, ашиглах чадвартай байх;
- Санхүүгийн эрсдэлийн удирдлага болон санхүүгийн тайлагналын олон улсын стандартын талаар мэдлэгтэй;

**Давуу тал:**

- Актуарч, актуарчийн сургалтад хамрагдсан;
- Математик, статистик, эконометриксийн аргачлалыг ашиглан анализ хийж, эрсдэлийн санал боловсруулах, дүгнэлт гаргах чадвартай;

- Мэргэшсэн цол эзэмшдэг;

**Бүрдүүлэх материал:**

- Сонгон шалгаруулалтад орох хүсэлт;
- Төрийн албан хаагчийн анкет /маягт №1/;
- Боловсролын диплом, үнэмлэхийн хуулбар;
- Иргэний үнэмлэхийн хуулбар;

**Хаяг:** Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 5-р хороолол, 10Б байр, Бизнес тауэр, 20 давхар, “Үндэсний давхар даатгал” ХК, хүний нөөцийн менежер Т.Уянга

**Холбоо барих утас:** 7577-0002

**И-мэйл:** uyanga@mongolianre.com

**Анкет ирүүлэх сүүлийн хугацаа:** Сонгон шалгаруулалтад орох хувь хүмүүсийн хүсэлт, материалыг 2026 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 10:00 цаг хүртэл дээрх хаягаар хүлээн авна.

**“ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ” ХК**